

## Магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурал

### УДИРДАМЖ

#### Нэг. Үндэслэл

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах тухай МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Захирлын тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МУИС-ийн ШУС-ийн Эдийн засгийн тэнхмийн магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахад энэхүү удирдамжийг баримтлана.

Магистрант, докторантын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэхэд энэхүү эрдэм шинжилгээний хурлын үндсэн зорилго оршино.

#### Хоёр: Хамрах хүрээ

МУИС-ийн ШУС-ийн Эдийн засгийн тэнхмийн магистр, докторын түвшинд сурч байгаа оюутнууд хамрагдана.

Нийгэм, эдийн засаг, статистик, хүн ам зүйн салбарын хүрээнд илтгэлийн сэдвийг магистрант, докторант өөрөө (шаардлагатай бол удирдагч багшийн зөвлөмжийн дагуу) сонгох ба ганцаарчилсан байдлаар оролцоно.

#### Гурав: Хугацаа

Магистр, докторын түвшний оюутнуудын илтгэлийг 2020 оны 4-р сарын **XX-ны XX** цаг хүртэл [dashdulam\\_87@yahoo.com](mailto:dashdulam_87@yahoo.com) хаягаар болон МУИС-ийн хичээлийн 5-р байрны 608 (тэнхмийн туслах ажилтан Д.Дашдулам) тоот өрөөнд хэвлэмэл байдлаар хүлээн авна. Илтгэлийн тоог хязгаарлахгүй. Илтгэлийг хэлэлцэн, шалгаруулах хурал 2020 оны 4-р сарын **XX-ны XX** цагаас МУИС-ийн хичээлийн 5-р байрны **XX** тоот өрөөнд болно.

#### Дөрөв: Илтгэлд тавигдах шаардлага

4.1 Илтгэл нь агуулгын хувьд дараах бүлгүүдийг багтаасан байна. Үүнд:

- Судалгааны хураангуй (абстракт)
- Удиртгал (Үүнд, судалгааны үндэслэл, зорилго, зорилт, ач холбогдол)
- Сэдвийн судлагдсан байдал
- Онол, арга зүйн хүрээ
- Судалгааны ажлын үр дүн
- Дүгнэлт, санал зөвлөмж
- Ашигласан материалын жагсаалт

4.2 Бичилт, боловсруулалтын хувьд дараах шаардлагыг хангасан байна.

- Хураангуй (абстракт) 100-150 үгтэй байна.
- Илтгэлийг word хэлбэрээр, А4 цаасны хэмжээнд, үсгийн хэмжээг 11, мөр хоорондын зайг 1.5, хуудасны хүрээг normal байхаар тохируулж, нийтдээ 10-15 хуудсанд багтаана.
- Илтгэлийн нүүр хуудсанд дараах мэдээллийг оруулсан байна. Үүнд:
  - Судалгааны сэдэв
  - Илтгэгчийн овог нэр
  - Илтгэгчийн цахим хаяг, утасны дугаар
  - Удирдагчийн нэр, эрдмийн зэрэг, цол
- Хуралд зориулсан үзүүлэн илтгэл нь powerpoint, latex зэрэг программ хангамж дээр, нийт 15 минутын хугацаанд танилцуулагдахаар бэлтгэгдсэн байна.

### **Тав: Шалгаруулах журам**

Илтгэл шалгаруулах комиссын бүрэлдэхүүн хуралд тавигдсан илтгэлүүдийг дараах шалгуураар дүгнэнэ. Үүнд:

- Судалгааны ажлын үр дүн, ач холбогдол (Судалгааны зорилгоо тодорхойлсон байдал, сэдвээ судалсан байдал, судалгааны дүгнэлт оновчтой эсэх, зорилго хангагдсан эсэх )- 30 оноо
- Судалгааны ажлын арга барилд суралцсан байдал (Академик хэв шинжээр бичигдсэн эсэх, судалгаанд ашигласан арга зүй, тоон өгөгдлийн нийцтэй байдал, судалгааны боловсруулалт, дүн шинжилгээ)- 30 оноо
- Илтгэх ур чадвар-20 оноо
- Ажлаа өөрийн болгож, эзэмшсэн байдал-10 оноо
- Асуултанд хариулсан байдал -10 оноо

Эхний гурван байрт шалгарсан магистрант, докторантад МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын хуралд илтгэлээ танилцуулах эрх олгоно.

Магистр, докторын түвшинд суралцаж байгаа оюутнуудад эрдэм шинжилгээний 1 багц цаг тооцох асуудлыг илтгэл шалгаруулах комиссын дүгнэлтээр шийдвэрлэнэ.

ЭШХ-ыг зохион байгуулах ажлын хэсэг:

МУИС, ШУС-ийн Эдийн засгийн тэнхмийн дэд профессор

Г.Цагаач

МУИС, ШУС-ийн Эдийн засгийн тэнхмийн дэд профессор

Б.Мягмарсүрэн

2019 оны 10-р сарын 23